



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/203

Зуунмод сум

Аймгийн 2022 оны нэгдүгээр ээлжийн
цэргийн жинхэнэ албаны татлагын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, Засгийн газрын 2021 оны мн/132 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2022 оны н/67 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг 04 дүгээр сарын 24-нөөс 04 дүгээр сарын 28-ны өдрүүдэд 5 суманд, 05 дугаар сарын 01-нд нэгдсэн татлагыг аймгийн төв дамжинд тус тус зохион явуулсугай.

2. Цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, цэрэг татлага явуулах хуваарийг хоёрдугаар, цэрэг татлагын ажилд шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хугацаат цэргийн албанд шинээр татагдах болон гэрээт цэргийн албанд элсэгчдэд эрүүл мэндийн үзлэгийг чанартай явуулж, эрүүл мэнд, бие бялдарын хөгжил сайтай, ял шийтгэл гэмт хэрэгт холбогдож байгаагүй, ёс суртахууны зөв төлөвшилтэй иргэдийг сонгон, өгөгдсөн даалгаврыг бүрэн биелүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, цэрэг татлагын товчооны дарга (М.Отгонбат), Цэргийн штабын дарга (дэд хурандаа Т.Төмөрчөдөр)нарт тус тус үүрэг болгосугай.

4. Цэрэг татлагын товчоонд ДААЛГАХ нь:

а/ Цэрэг татлагын товчооны гишүүд, ажиллагсдын ажил үүргийн хуваарийг тогтоон, цэрэг татлагын ажилтай холбоотой хууль, эрх зүйн баримт, тухайн ажлыг гүйцэтгэх зааварчилгаа өгч, бусад зохион байгуулалтын арга хэмжээ авах.

б/ Цэргийн жинхэнэ албаны татлагын ажлыг сайтар зохион байгуулж, Засгийн газрын 2019 оны 441 дүгээр тогтоол, иргэнийг цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэх журмын дагуу тэнцүүлэн татаж Зэвсэгт хүчний Жанжин штабаас өгсөн хяналтын тоон даалгаврыг биелүүлэх.

в/ Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйл, 13 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлж, цэрэг халалт татлагын явцад байнгын хяналт тавьж, цэрэг татлагын товчооны үйл ажиллагаатай холбогдуулан иргэдээс гаргасан санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх.

г/ Аймгийн цэрэг татлагын товчоо, эмч нарын комисс сумдад ажиллахдаа төлөвлөгөө, маршрут гаргаж ажиллах.

5. Монгол Улсын Засгийн газрын 441 дүгээр тогтоолын 2.2.1, эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.2-т заасны дагуу 8 төрлийн шинжилгээ оношлогоог цэргийн

насны залуучуудаас үнэ төлбөргүй авах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга (Н.Энхтайван), Нийгмийн даатгалын хэлтсийн дарга (Ж.Эрдэнэжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

6. Цэргийн насны залуучуудад цэрэг татлага эхлэхээс өмнө сүрьеэгийн сорил тавих, суурь өвчтэй иргэнийг цэргийн албанд татахгүй байх, сүрьеэгийн ойрын хавьталтай цэргийн насны залуучуудын судалгаа гаргах ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа)-т даалгасугай.

7. Гэмт хэргийн холбогдлоор хуулийн байгууллагад шалгагдаж байгаа залуучуудыг цэргийн албанд татахгүй байх талаар мэдэгдэж, сахилга зохион байгуулалтад хяналт тавьж, цэрэг татлагын товчооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийг хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт үүрэг өгч, хамгаалалтыг тогтоосон журмын дагуу чанд сахиж, хамтран ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (дэд хурандаа Ч.Алтанхуяг)-д үүрэг болгосугай.

8. Цэргийн жинхэнэ албаны татлагаар зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байр, товлосон газарт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2, Зөрчлийн тухай хуулийн 15.17 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээ авч ажиллахыг Цэргийн штаб (дэд хурандаа Т.Төмөрчөдөр)-г үүрэг болгосугай.

9. Аймгийн төвд нэгдсэн татлага явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлж, байраар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Н.Төмөрбаатар)-т даалгасугай.

10. Цэргийн насны (18-25) насны залуучуудад зарлан дуудах хуудсыг цаг хугацаанд нь олгож цэрэг татлага явуулах байрыг урьдчилан бэлтгэж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

11. Хугацаат цэргийн албанд татагдсан иргэнийг тээвэрлэх арга хэмжээ зохион байгуулахдаа хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөж, автотехникийн бүрэн бүтэн байдлыг сайтар хангаж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

12. Цэрэг татлагын зардалд шаардагдах 4,493.875 (дөрвөн сая дөрвөн зуун ерэн гурван мянга найман зуун далан тав) төгрөгийн зардлыг аймгийн 2022 оны төсвийн хуваарилагдаагүй зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д, шилэн дансанд байршуулахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

13. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/586 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР



Аймгийн Засаг даргын 2022 оны 04 -р сарын 14 -ны өдрийн 4/203-р захирамжийн 1 -р хавсралт



ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Цэрэг татлагын товчооны дарга:

М.Отгонбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Цэрэг татлагын товчооны орлогч дарга:

Т.Төмөрчөдөр (Цэргийн штабын дарга, дэд хурандаа)

Гишүүд:

Н.Төмөрбаатар (Онцгой байдлын газрын дарга, хурандаа)

Ч.Алтанхуяг (Цагдаагийн газрын дарга, Хурандаа)

Ю.Бямбацогт (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

С.Мөнхтуяа (Эрүүл мэндийн газрын дарга)

Н.Энхтайван (Аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга)

Д.Батцэцэг (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Ж.Эрдэнэжаргал (Нийгмийн даатгалын хэлтсийн дарга)

Б.Бадарч (Дайчилгааны офицер)

Сумын Засаг дарга- 27 хүн)

(Сумын Засаг даргын Тамгын газрын дарга- 27 хүн)


(Багийн Засаг дарга- 97 хүн)

(Цэрэг татлагын товчооны нарийн мэргэжлийн эмч сувилагч нар -11 хүн)

Нарийн бичгийн дарга:

С.Солонго (Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, ахмад)

___оОо___



Аймгийн Засаг даргын 2022 оны 04 -р сарын 14 -ны өдрийн 1/203-р захирамжийн 2 -р хавсралт



2022 ОНЫ НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН АЖЛЫГ
СУМ, АЙМАГТ ЯВУУЛАХ ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООНЫ
ҮЗЛЭГИЙН ХУВААРЬ

Нэг. Цэрэг татлагын товчоонд ажиллах хүн техник.

№	Суманд	Суманд		Аймгийн төвд		Тайлбар
		Сар өдөр	Цаг минут	Сар өдөр	Цаг минут	
1.	Алтанбулаг	IV/24	09.00-16.00	IV/30	09.00-10.30	Цэргийн зарлан дуудах хуудас авсан иргэдийг тогтоосон өдөр цагт цэрэг татлагын байр болон товлосон газар бэлэн байлгах, цэрэг татлага явуулах байрыг урьдчилан бэлэн болгож ариутгал халдваргүйжилтийг хийж үзлэгт орж байгаа залуучуудыг амны хаалттай оруулахад анхаарч ажиллах.
2.	Баян-Өнжүүл	IV/25	09.00-16.00	IV/30		
3.	Бүрэн	IV/26	09.00-16.00	IV/30	10.30.11.30	
4.	Дэлгэрхаан	IV/27	09.00-16.00	IV/30		
5.	Өндөрширээт	IV/28	09.00-16.00	IV/30	11.30-13.00	

а/ Цэргийн штабын дарга-1, Дайчилгааны офицер-1, Орон нутгийн хамгаалалт сургалтын офицер-1, жолооч-1 /суудлын машин/ 1ш, нийт 4 хүн явна.

б/ Аймгийн нэгдсэн эмнэлгээс

Ерөнхий эмч болон дотрын эмч -1, Мэдрэлийн эмч-1, Шүдний эмч-1, Мэс заслын эмч -1, Сүрьеэгийн эмч-1, Нүдний эмч-1, Чих хамар хоолойн эмч-1, Арьс харшлын эмч-1, жолооч-1 /машинтай/, сумдын их эмч, сувилагч нарийн бүрэлдэхүүн нийт 9 хүнтэй ажиллана.

в/ Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон сумын хэсгийн төлөөлөгч офицер-1, цагдаа-1 албан хаагч нь цэргийн албанд татагчдын сахилга зохион байгуулалт дээр анхаарч ажиллана.

ТӨЛӨВЛӨСӨН:
ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА
ДЭД ХУРАНДАА

Т.ТӨМӨРЧӨДӨР

Аймгийн Засаг даргын 2022 оны 04-р сарын 14-ны өдрийн А/2023-р захирамжийн 3-р хавсралт



2022 ОНЫ НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

Үе шат	2020 оны нэгдүгээр ээлжийн төсвийн зардал /төгрөг/				
	Томилолт	Шатахуун	Байр хоол	Бичиг хэргийн зардал	Бүгд
Сумдад болон аймгийн дамжинд ажиллах	13 хүн 5 суманд 5 хоног ажиллана. 13x5x26500=1,722,500 төг	13 суманд нийт 838 км явна. А./уаз-452/ 1ш 838км 0.18=150 л 150л x 2440=366.000 Б. / старекс / 1 x 838 км 0.15=125 л x3035 = 379,375	А.Цэрэг татлагын товчооны 70 хүн 1 өдөр хооллоно. Өдөр 1 хүн 9000 x 70хүн 630,000	1. Зарлан дуудах хуудас 3500ш x 40төг=140,000 2.Принтерийн хор 45,000 3. Батлан хамгаалах сурталчилгааны тараах материал / сумдад/ 1500ш x 650 = 975,000 ✓ 4.Аннос 150,000 төг ✓ 4. Хөлтэй слайдан самбар 1 ш x 60,000 ✓ 5. Бичгийн цаас 2 боодол13000 x 3= 26,000	
Дүн	1,722,500	745,375	630,000	1,396,000	4,493,875

ТӨЛӨВЛӨСӨН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГЫН БӨГӨӨД ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООНЫ ДАРГА  М.ОТГОНБАТ

ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Т.ТӨМӨРЧӨДӨР

ХЯНАСАН:

ТӨРИЙН САНГИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Ч.ЦЭЦЭГСҮРЭН

